



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/193

Мандалговь

Гоби Голден Сийдс ХХК-тай  
гэрээ байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Дундговио ногооруулья" дэд хөтөлбөрийн батлагдсан зардлаас Цэнгэлдэх хүрээлэнгийн зүлэгжүүлэлтийн үр нийлүүлэх ажлыг "Гоби Голден Сийдс" ХХК-тай 3,000,000 (гурван сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2.Гэрээнд заасан хугацаанд Цэнгэлдэх хүрээлэнгийн зүлэгжүүлэлтийн үр нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Гоби Голден Сийдс" ХХК-ийн ахлагч (А.Уранчимэг)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150461